ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	901,278.9	5%	489,118.3	35%	-412,160.6	-46%
Мөнгөн хөрөнгө	209,723.3	3%	189,197.4	14%	-20,525.8	-10%
Авлага	296,573.3	5%	239,313.1	17%	-57,260.2	-19%
Урьдчилгаа		0%		0%	0.0	0%
Бараа материал	394,982.3	6%	60,607.7	4%	-334,374.6	-85%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,310,004.8	85%	896,570.2	65%	-4,413,434.6	-83%
Үндсэн хөрөнгө	7,231,732.1	116%	1,823,805.7	132%	-5,407,926.4	-75%
Хуримтлагдсан элэгдэл	(1,921,727.3)	-31%	-927,235.6	-67%	994,491.8	-52%
Нийт хөрөнгө	6,211,283.7	100%	1,385,688.4	100%	-4,825,595.27	-78%
Өр төлбөр	37,826.9	1%	133.5	0%	-37,693.4	-100%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,173,456.8	99%	1,385,555	100%	-4,787,901.9	-78%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,211,283.7	100%	1,385,688.4	100%	-4,825,595.3	-78%

Эх сурвалж: Богд сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Эргэлтийн бус хөрөнгийн дүн өмнөх оноос 4,045,027.4 мянган төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэндийн салбарын шинэчлэлтэй холбоотойгоор сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвийн хөрөнгийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 189,197.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 189,197.4 мянган төгрөг болж 20,525.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<u>Касст байгаа бэлэн мөнгө</u>				
<u>Банканд байгаа бэлэн мөнгө</u>	209,723.3	189,197.4	-20,525.8	100%
Орон нутгийн ерөнхий орлого	91,019.6	147,359.5	56,339.9	78%
Орон нутгийн хөгжлийн сан	18,125.7	15,595.9	-2,529.8	8%
Сум хөгжүүлэх сан	100,577.9	26,242.1	-74,335.9	14%
<u>Замд яваа мөнгөн хөрөнгө</u>				
<u>Хадгаламж</u>				
Дүн	209,723.2	189,197.4	-20,525.8	100%

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 189,197.4 мянган төгрөг нь төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн 52,994.8 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 15,595.9 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 26,242.1 мянга, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 94,364.6 мянган төгрөг байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 296,573.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд оны эцсийн үлдэгдэл 239,313.1 мянган төгрөг болж 57,260.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл / мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага			-
Татаас санхүүжилтын авлага	130,468.5		(130,468.5)
Байгууллагаас авах авлага	58,773.9	50,000.0	(8,773.9)
Хувь хүмүүсээс авах авлага	5,000.0	5,000.0	-
Хувь хүмүүст олгосон зээл	102,330.9	184,313.1	81,982.2
Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл			-
Дүн	296,573.3	239,313.1	-57,260.2

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 77 хувь буюу 184,313.1 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн авлага, 23 хувь буюу 55,000.0 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага байна.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ЭМТ	130,468.5		-130,468.5	0.0
СХС	102,330.9	184,313.1	81,982.2	77.0
ЕБС	8,773.9		-8,773.9	0.0
ОНХСан	55,000.0	55,000.0	0.0	23.0
НИЙТ ДҮН	296,573.3	239,313.1	-57,260.2	100.00

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 102,330.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 119,000.0 мянган төгрөгийн зээл олгож 46,664.8 мянган төгрөгийн зээлийн авлагыг барагдуулж оны эцэст 184,313.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 394,982.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд оны эцсийн үлдэгдэл 60,607.7 мянган төгрөг болж, 334,374.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	30,896.6		-30,896.6
Эм боох материал	46,575.3	65.0	-46,510.3
Бичиг хэргийн материал	20,127.7	8,394.6	-11,733.1
Аж ахуйн материал	214,157.6		-214,157.6
Сэлбэг хэрэгсэл	13,382.5		-13,382.5
Түлш, шатах тослох материал			0.0
Барилгын засварын материал	12.0		-12.0
Хүнсний материал	6,098.9		-6,098.9
Бусад хангамжийн материал	50,400.6	49,908.2	-492.4
Мал амьтад	13,331.0	2,240.0	-11,091.0
Нөөцийн бараа			0.0
Дүн	394,982.3	60,607.7	-334,374.6

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 60,607.7 мянган төгрөг болж өмнөх оноос 334,374.6 мянган төгрөгөөр буурсан Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв нь улсын төсвийн байгууллага болсонтой холбоотой тухайн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	4,848.5	4,560.6	(287.9)	7.5
ЗДТГ	74,962.6	56,047.1	(18,915.4)	92.5
Соёл	24,889.9		(24,889.9)	-
ЭМТ	85,614.6		(85,614.6)	-
ОНХС			-	-
ЕБС	145,685.3		(145,685.3)	-
Цэцэрлэг	58,981.4		(58,981.4)	-
НИЙТ ДҮН	394,982.3	60,607.7	-334,374.6	100.0

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 62,543.2 мянган төгрөгийн бараа материалын 62,543.2 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, нийт хасагдсан 396,917.9 мянган төгрөгийн 315,171.2 мянган төгрөг буюу 79.4 хувь нь шилжүүлсэн бүтцийн өөрчлөлттэй холбоотой байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	62,543.2	Хасагдсан	396,917.9
Худалдан авсан	62,543.2	Худалдсан, зарцуулсан	81,299.7
Хандиваар		Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	315,171.2
бусад		бусад	447.0

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,231,732.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд оны эцсийн үлдэгдэл 1,823,805.7 мянган төгрөг болж 5,407,926.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	7,144,285.1	1,809,558.7	-5,334,726.4	75.2
Барилга байгууламж, орон сууц	4,833,823.0	546,303.1	-4,287,519.9	30.0
Тээврийн хэрэгсэл	249,124.8	232,864.8	-16,260.0	12.8
Машин тоног төхөөрөмж	864,529.0	161,103.2	-703,425.8	8.8
Тавилга эд хогшил	466,499.2	202,227.5	-264,271.7	11.1
Зам гүүр байгууламж	438,474.3	438,474.3	0.0	24.0
Түүх соёлын дурсгалт зүйл	458.9	0.0	-458.9	0.0
Дуусаагүй барилга байгууламж			0.0	0.0
Номын фонд	51,090.1	300.0	-50,790.1	0.0
Бусад үндсэн хөрөнгө	240,286.0	228,286.0	-12,000.0	12.5
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	87,447.0	14,247.0	-73,200.0	0.8
Программ хангамж	2,229.0	659.0	-1,570.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	85,218.0	13,588.0	-71,630.0	0.7
НИЙТ ДҮН	7,231,732.1	1,823,805.7	-5,407,926.4	76.0

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвийн байгууллагууд улсын төсвийн байгууллага болсонтой холбоотой шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр 5,469,697.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	10,914.8	10,914.8	0.0	0.6
ЗДТГ	1,751,119.8	1,812,890.9	61,771.1	99.4
Соёл	1,811,388.8		-1,811,388.8	0.0
ЕБС	1,202,043.3		-1,202,043.3	0.0
Цэцэрлэг	1,107,382.0		-1,107,382.0	0.0
Эмнэлэг	1,348,883.4		-1,348,883.4	0.0
ОНХСан			0.0	0.0
НИЙТ ДҮН	7,231,732.1	1,823,805.7	-5,407,926.4	100.0

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 61,771.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 91.9 хувь буюу 56,771.0 мянган төгрөгийг хөрөнгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	61,771.0	Хасагдсан	5,469,697.00
Худалдан авсан	5,000.0	Худалдсан	
Хандиваар	56,771.0	Акталсан	
Шилжүүлэн авсан		Шилжүүлсэн	5,469,697.00
бусад		Бусад	

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 37,826.9 мянга, эцсийн үлдэгдэл 133.5 мянга ба 37,693.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	37,826.9	133.5	-37,693.4	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	15,665.4	133.5	(15,531.9)	100.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	21,561.4		(21,561.4)	-
Байгууллагад төлөх өглөг	600.1		(600.1)	-
Хувь хүмүүст өгөх өглөг			-	-
Дүн	37,826.9	133.5	(37,693.4)	100.0

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 130.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЗДТГ-ын ажиллагсадтай холбоотой өглөг байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ			-	-
ЗДТГ	8,771.9	133.5	(8,638.4)	23.19
Соёлын төв			-	-
ЕБС			-	-
ЭМТ	28,454.9		(28,454.9)	75.22
ОНХС			-	-

Цэцэрлэг			-	-
СХСан	600.1		(600.1)	1.59
ДҮН	37,826.9	133.5	(37,693.4)	100.0

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,173,456.8 мянга, эцсийн үлдэгдэл 1,385,554.9 мянган төгрөг болж, 4,787,901.9 мянган төгрөгөөр төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 12. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,939,703.9	485,100.1	(1,454,603.7)	35.0
Өмч: - Орон нутгийн оруулсан хөрөнгө	1,939,703.9	485,100.1	(1,454,603.7)	35.0
Хуримтлагдсан үр дүн	3,308,572.4	743,027.4	(2,565,545.1)	53.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	925,180.5	157,427.4	(767,753.1)	11.4
Дүн	6,173,456.8	1,385,554.9	(4,787,901.9)	100.0

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,787,901.9 мянган төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвийн байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр тухайн тайлант нэгтгэгдээгүйтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2021.12.17-ний өдрийн хуралдаанаар 4/06 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 287,708.6 мянга, хүү торгуулийн орлогыг 5,000.0 мянга, нийт 287,708.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	287,708.6	380,291.1	91,863.3	132.2
ЦХТА рлого /суутган/	118,000.0	77,888.9	(40,111.1)	66.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1,200.0	111.4	(1,088.6)	9.3
Бууны татвар	2,500.0	2,790.0	290.0	111.6
ИОТХ	15,000.0	85,866.9	70,866.9	572.4
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	10,152.1	8,152.1	507.6
Хадгаламжийн хүүгийн орлого	40,000.0	29,480.9	(10,519.1)	73.7
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	4,000.0	4,537.3	537.3	113.4
Малд ногдуулах албан татвар	59,908.6	55,391.0	(4,517.6)	92.5
Газрын төлбөр	3,600.0	1,555.0	(2,045.0)	43.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,000.0	9,278.5	278.5	103.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	32,000.0	101,380.0	69,380.0	-
ТТАМАТөлбөр	500.0	1,040.0	540.0	208.0
Ашигт малтмалын Нөөц Аш төлбөр		100.0	100.0	0

**Богд сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Бусад татвар		719.2	719.2	
2.Татварын бус орлого	5,000.0	4,530.0	(470.0)	90.6
2.1.Хүү торгуулийн орлого	5,000.0	4,530.0	(470.0)	90.6
Нийт дүн	292,708.6	384,821.1	91,393.3	131.5

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 131.5 хувь буюу 91,393.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар 70,866.9 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын албан татвар 540.0 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 69,380.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 8,152.1 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 278.5 мянга, төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна. Харин цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 40,111.1 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 1,088.6 мянга, бууны албан татвар 290.0 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 10,519.1 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 537.3 мянга, малын тоо толгойн албан татвар 4,517.6 мянга, газрын төлбөр 2,045.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь орлогыг нэр төрлөөр нь биелүүлэх тал дээр тодорхой арга хэмжээ бүрэн аваагүйтэй холбоотой байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1,000.0 мянган төгрөгийн орлогоос 9,252.8 мянган төгрөгийн орлого орсон байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 34,150.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 46,664.8 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,287,977.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,208,478.0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 985,479.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 222,998.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Богд сумын Засаг дарга	1,287,977.2	1,208,478.0	79,499.2	93.8
2	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	69,857.800	62,969.7	6,888.1	90.1
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	700.000	474.0	226.0	67.7
4	80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	6,313.200	6,313.2	0.0	100.0
5	80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	6,810.000	5,680.4	1,129.6	83.4
6	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	299,053.300	285,121.9	13,931.4	95.3
7	80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	80,318.000	78,327.6	1,990.4	97.5
8	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	2,000.000	2,000.0	0.0	100.0
9	80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	15,837.600	14,575.7	1,261.9	92.0
10	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	35,000.000	34,895.4	104.6	99.7
11	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	20,000.000	19,474.8	525.3	97.4
12	82212 хур хог хаягдал, орчны бохирдол	9,000.000	9,000.0	0.0	100.0
13	82310 Гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгаа	1,243.100	1,243.1	0.0	100.0
14	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	58,826.4	52,76.1	6,080.3	89.7

15	71702 Соёл урлаг	75,166.0	74,306.1	859.9	98.9
16	71801 Сургуулийн өмнөх боловсрол	50,550.6	50,259.3	291.3	99.4
17	71802 Ерөнхий боловсрол	178,535.2	167,091.5	11,443.7	93.6
18	70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт	18,400.0	18,106.9	293.1	98.4
19	83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	144,373.5	144,293.8	79.7	99.9
20	83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	59,908.6	39,807.6	20,101.1	66.4
21	83406 ОНХС -бусад	21,933.9	20,790.4	1,143.5	94.8
22	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	134,150.0	121,000.7	13,149.4	90.2
	Нийт дүн	1,287,977.2	1,208,478.0	79,499.2	93.8

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 2 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын орон нутгийн төсвөөс санхүүжих төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.17-ний өдрийн 4/06 дугаар тогтоолоор нийт 1,347,885.0 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	134,408.1	85,188.5	49,219.6
Засаг даргын Тамгын газар	345,947.9	442,776.4	-96,828.5
Сургууль	240,609.4	240,609.4	0.0
Цэцэрлэг	76,249.1	76,249.1	0.0
Эрүүл мэндийн төв	58,826.4	58,826.4	0.0
Соёлын төв	72,122.5	72,122.5	0.0
Сум хөгжүүлэх сан		120,450.0	-120,450.0
Орон нутгийн хөгжлийн сан		251,662.7	-251,662.7
Нийт дүн	928,163.4	1,347,885.0	-419,721.6

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2021.12.17-ний өдрийн 4/06 дугаар тогтоолоор анх 1,347,885.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2022.06.10-ний өдрийн 06/02 дугаар тогтоолоор 59,907.8 мянган төгрөгөөр бууруулж 1,287,977.2 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 166,307.4 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 584,811.2 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 292,708.6 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 35,150.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 209,000.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 581,811.2 мянга, орон нутгийн орлогоос 381,476.1 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс

165,392.7 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 46,674.4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 9,252.8 мянган төгрөгийн санхүүжилт авч 52,994.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН-т төвлөрсөн
ЗДТГ	462,452.0	444,638.4	17,813.6	96.1	26,066.4
ИТХ	83,681.0	75,437.3	8,243.7	90.1	8,253.3
Соёлын төв	75,166.0	74,306.1	859.9	98.9	859.9
Сум хөгжүүлэх сан	134,150.0	121,000.7	13,149.4	90.2	-
Сургууль	178,535.2	167,091.5	11,443.7	93.6	11,443.7
Цэцэрлэг	50,550.6	50,259.3	291.	99.4	291.3
ЭМТ	58,826.4	52,746.1	6,080.3	89.7	6,080.3
ОНХС	244,616.0	222,998.6	21,617.4	91.2	
Нийт дүн	1,287,977.2	1,208,478.0	79,499.2	93.8	52,994.9

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,208,478.0 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 17,813.6 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 8,243.7 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 21,617.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 20,887.5 мянга, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,987.2 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8,592.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 21,987.7 мянган төгрөгийг зарцуулж 9,479.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	5,250.0	15,264.1	20,514.1
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,250.0		5,250.0
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		15,264.1	15,264.1
НИЙТ ЗАРЛАГА	5,250.0	15,264.1	20,514.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,088.6	14,177.1	19,265.7
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	161.5	1,086.9	1,248.4
өсөвт төвлөрүүлсэн	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Богд сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 35,000.0 мянган төгрөгөөр баталж 34,895.4 мянган төгрөгийг зарцуулж 104.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Сумын Орон нутгийн нөөц хөрөнгөөс оны аваргын шагналд 5,000.0 мянга, Гэгээнтэн лам нарын уул ус тахих, сүсэгтэн олонд ном хуруулах үеийн зардал 1,091.5 мянга, эмэгтэйчүүдийн баярын үйл ажиллагаанд 700.0 мянга, Монгол цэргийн баярын зөвлөгөөний үйл ажиллагааны зардалд 1,010.5 мянга, тэмээчдийн зөвлөгөөн зохион байгуулах 1,349.0 мянга, Сумын 2022 оны ээлжит цэрэг татлаг зохион байгуулахтай холбоотой цэргүүдэд сургалт зохион байгуулах, бөхийн барилдааны шагналын зардал 700.0 мянга, уяачдын наадам зохион байгуулах 1,900.0 мянга, Баянхонгор аймаг үүсгэн байгуулагдсан 80 жилийн ойн баярын тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний үеэр Баянхонгор аймагт нутгийн уугуул иргэдийг хүлээн авч байрлуулах, гэр бэлтгэн хоолны зардалд 1,000.0 мянга, Аймгийн заан цол хүртсэн Ч.Дашид хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардалд 2,200.0 мянга, Залуучуудын өдөрлөгийн шагнал хоолны зардалд 1,420.0 мянга, элсэгчдийн ерөнхий шалгалтад сурагчдыг бэлтгэж амжилт гаргасан багш нарт урамшуулал 1,500.0 мянга, ЗДТГ-ын оны аварга шалгаруулах шагналын зардалд 2,000.0 мянга, хүүхдийн баярын үйл ажиллагаанд 200.0 мянга Хүүхдийн Цэцэрлэгийн 2022 оны гимнастикийн аварга анги шалгаруулах тэмцээний шагналд 200.0 мянга, Өсвөрийн жудо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлэх 300.0 мянга, Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлсэн баг тамирчид улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг 1,500.0 мянга, Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, тамирчдад хувцасны зардалд 1,500.0 мянга, нийт 23,771.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлсэн.

3.8 Аудитын гол асуудал

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 97 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 83.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,287,977.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,208,478.0 мянган төгрөгийг зарцуулж, 93.8 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 292,708.6 мянган төгрөг төвлөрүүлэхээс 384,821.1 төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого хувь буюу 91,393.3 мянган төгрөгөөр давж биелсэн боловч 6 нэр төрлийн 58,751.4 мянган төгрөгийн орлого тасарсан ба татварын нэр төрлөөр биелүүлэх зөвлөмж хүргүүлсэн.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Богд сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Богд сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохиж	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс				
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЗДТГ	1	1			1					
ИТХурал	1	1			1					
ОНХС	1	1			1					
СХС	1	1			1					
НИЙТ ДҮН	4	4			4	0	0	0		0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 299,778.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 15,991.0 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 282,187.0 мянган төгрөгийн 7 албан шаардлага, 800.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт									
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж		Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил												
ИТХурал	1	0					1	0				
ЗДТГ	5	39,693.5			2	4,022.5	3	35,671.0				
ОНХСан	5	256,584.5			4	11,968.5	1	244,616.0				
СХС	0	-										
СТА зөрчлийн дүн	11	296,278.0	-	-	6	15,991.0	5	280,287.0				
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал												
ЗДТГ	1	800.0							1	800.0		
ОНХСан	1								1			
ИТХурал	3	1,900.0					3	1,900				
СХС	0											
Нийцлийн аудитын дүн	5	2,700.0	0	-	0	-	3	1,900	2	800		
Нийт дүн	16	298,978.0	0		6	15,991.0	8	282,187.0	2	800.0		

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 296,278.0 мянган төгрөгийн 11 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 2,700.0 мянган төгрөгийн 4 зөрчил тус тус илэрсэн байна.

Зөрчлийг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
Засаг даргын Тамгын газар		40,493.5			
1	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2022.10.21-д Түйн долгио ХХК руу эмнэлгийн ариун зөврийн ерөөний засварт 8,000.0 мянган төгрөгийг шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан байна.	8,000.0	Албан шаардлага өгөх	Дарга Ня-бо	Б.Бурмаа Х.Пүрэвсүрэн
2	Засаг даргын нөөц хөрөнгөөс оны аваргын шагнал, эмэгтэйчүүд, Монгол цэргийн баяр, хүүхдийн баяр, Залуучуудын өдөрлөг, тэмээчдийн зөвөлгөөн, Сумын 2022 оны ээлжит цэрэг татлагын сургалт зардал, нутгийн уугуул иргэдийг хүлээн авч байрлуулах, гэр бэлтгэх, ерөнхий шалгалтад сурагчдыг бэлтгэж амжилт гаргасан багш нарт урамшуулал, тэмцээний шагнал зэрэгт захирамжаар зориулалт бусаар зарцуулсан байна	27,671.0	Албан шаардлага өгөх	Дарга Ня-бо	Б.Бурмаа Х.Пүрэвсүрэн
3	Засаг даргын нөөц хөрөнгөөс ЗДТГ-ын аварга шалгаруулах шагналын зардалд 2,000.0 мянга, Уаячдын наадам зохион байгуулахад 1,900.0 мянган төгрөг зарцуулсан байна.	3,900.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ня-бо	Б.Бурмаа Х.Пүрэвсүрэн
4	Бараа үйлчилгээний бусад зардлаас 2022.07.07-д 122.5 мянган төгрөгийн хоолны зардлыг шилжүүлсэн байна.	122.5	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ня-бо	Б.Бурмаа Х.Пүрэвсүрэн
5	Тухайн байгууллага нь 2022 оны санхүүгийн талинад бараа материал 56,047.1 мянга, үндсэн хөрөнгө 1,812,890.9 мянга нийт 1868938.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 2022 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй байна.		Албан шаардлага өгөх	Дарга Ня-бо	Б.Бурмаа Х.Пүрэвсүрэн
6	Нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардлаас ЗДТГ-ын даргын 2022.05.30-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдийн бэлэглэний үнэнд 800.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	800.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ня-бо	Б.Бурмаа Х.Пүрэвсүрэн
ИТХ		1,900.0			
1	Тухайн байгууллага нь 2022 оны санхүүгийн талинад бараа материал 4,560.0 мянга, үндсэн хөрөнгө 10,914.8 мянга нийт 15,474.8 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 2022 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй байна		Албан шаардлага өгөх	Дарга Ня-бо	Д.Дандар Х.Пүрэвсүрэн
2	Бараа үйлчилгээний бусад зардлаас Аймгийн заан цол хүртсэн Ч.Дашид хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардалд 400.0 мянга, 2022.11.02 ж.Баттунгалагт 40 нэмэх тэмцээний үнэнд 200.0 мянган төгрөг, Хичээл практикийн зардлаас 2022.06.30 Э.Эрдэнэчимэгт Баянцагаан суманд болсон ИТХ-ын бүсийн уулзалтын арга хэмжээний оролцооны төлбөрт 200.0 мянга, ардын авьяастан Б.Азбаярт хүндэтгэл үзүүлсэн 100.0 мянган төгрөг тус тус шилжүүлсэн байна.	900.0	Албан шаардлага өгөх	Дарга Ня-бо	Д.Дандар Х.Пүрэвсүрэн
3	Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2022.09.22-ны өдрийн А/18 дугаар тушаалаар аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулсан "Нутгийн удирдлагын байгууллагын чадавхыг бэхжүүлэх, ажлын уялдаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, шинэ санаачлага, тэргүүн туршлага судлах" уулзалт аялалын зардалд хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2022.09.23-д 1,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.	1,000.0	Албан шаардлага өгөх	Дарга Ня-бо	Д.Дандар Х.Пүрэвсүрэн
Орон нутгийн хөгжлийн сан		256,584.5			
1	Богд сумын ИТХ-ын 2021.12.17-ны өдрийн 4/06 дугаар малчдад зориулсан сургалт сурталчилгааны зардалд 10,000.0 мянган төгрөг батлагдсан бөгөөд багийн наадам зохион байгуулах зардалд 3,192.6 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.	3,192.6	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ня-бо	Д.Дандар Х.Пүрэвсүрэн
2	Сумын ЗДТГ болон сумын төвийн нийтийн эзэмшлийн хог ачуулсаны хөлсөнд 2022.07.27-д 500.0 мянган төгрөгийг иргэн С.Цэвээнхүүд, хог ачуулсаны шатахууны зардалд 1496.4 мянган төгрөгийг Жаргалант Богд ХХК руу тус тус шилжүүлсэн байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2022 оны төсөл арга хэмжээнд батлагдаагүй байна.	1,870.9	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ня-бо	Д.Дандар Х.Пүрэвсүрэн

3	Сумын Засаг даргын 2022.11.30-ны өдрийн А/124 дугаар захирамжаар "тэмээний баяр зохион байгуулах" арга хэмжээнд 1,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1,000.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ня-бо	Д.Дандар Х.Пүрэвсүрэн
4	Тус сангаас 2022.12.22-д Б.Мөнхбаатарт "ЗДТГ-ын сандалны үнэ"-нд 5.905.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.	5,905.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ня-бо	Д.Дандар Х.Пүрэвсүрэн
5	Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй сумын ИТХ нь эзэмшигч тогтоогоогүй байна.	244,616.0	Албан шаардлага өгөх	Дарга Ня-бо	Д.Дандар Х.Пүрэвсүрэн
	Нийт дүн	298,978.0			

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс 116 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг мэдээллийн хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	12	12	7	2	1	2
2	Хагас жил	2	2	2			
3	Улирал бүр	2	8	3	4	1	
4	Сар бүр	5	60	49	11		
5	Тухай бүр	6	72	55	5	12	
	Нийт	27	154	116	22	14	2

Эх сурвалж. Богд сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Богд сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад 2,700.0 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч 1,900.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 800.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 алдаа, зөрчил илэрснээс алдаа, зөрчил давтан гаргахгүй байх н 4 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Зөвлөмж	2	0	2	0			100.0
Нийт	2	0	2	0			100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын ЗДТГ, ИТХ, соёлын төв, ОНХС, Сум хөгжүүлэх сан хариуцсан нягтлан бодогч Х.Пүрэвсүрэн ажлаа хаяж явснаас шалтгаалж тухайн байгууллагуудыг санхүүгийн тайланг хугацаандаа ирүүлээгүй, ба 2023.03.01-д санхүүгийн тайлангуудыг ирүүлсэн боловч орлого, зарлагын гүйлгээ дутуу санхүүгийн тайлан шаардлага хангахгүй байсан тул Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланг дахин гаргаж ирүүлсэн болно. Үүнтэй холбоотой дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай байна.

- ЗДТГ, ИТХ-ын 10-12 сарын нярвын тайлан болон цалингийн дэлгэрэнгүй цэст, нийгмийн даатгалын мэдээ, шатахууны тооцоог аудитад ирүүлээгүй учир тус сумын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүү, хяналт, дотоод аудитын газар санхүүгийн хяналт, шалгалт хийх шаардлагатай.
- Тус сумын дээрх байгууллагын нягтлан бодогч нь ажлаа хаяж явсан гэх боловч Улаанбаатар хотоос 2023 оны цалингийн болон зардлын гүйлгээ хийж байгаад аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэс анхаарах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Богд сумын Засаг даргын санхүүг ийн нэгтгэсэн тайланд 46,541.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс алдаа зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 1,088.6 мянга, бууны албан татвар 290.0 мянга, малын тоо толгойн албан татвар 4,517.6 мянга, газрын төлбөр 2,045.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна

Өгсөн зөвлөмж: Татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлж зөвлөмжийг хүргүүлэв.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Богд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй япон улсын тусламжаар өгсөн нэг бүр нь 6,000.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг мотор биетээр байхаар дутагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын

байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Дутагдсан хөрөнгийг хууль хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлэх зөвлөмжийг хүргүүлэв.

3. Хууль журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс 116 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг мэдээллийн хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь бүрэн мэдээлэх

4.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт

1.Сумын төсөвт байгууллагууд санхүүгийн тайлан болон сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх, 8.9.2 дахь цаглаварт хугацаандаа Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй болно.

Мөн сумын ЗДТГ нь санхүүгийн тайланд төрийн сангийн дансны 63,874.8 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ нэмэлт санхүүжилтийн дансны 1,957.2 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг дутуу бүртгэсэн, 2022 оны 10-12 сарын 81,626.4 мянган төгрөгийн цалин НДШ-ийн зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, сумын ИТХ нь санхүүгийн тайланд төрийн сангийн дансны 3,437.1 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ зөрүүтэй, нэмэлт санхүүжилтийн дансны 3,574.1 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ дутуу бүртгэсэн зөрчил илэрлээ

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1. "Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", 15 дугаар зүйлийн 15.1.1. "Шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.1. "Аж ахуйн бүх ажил гүйлгээ", 14.4.2. "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3. "Аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр", 14.4.5. "Бүх орлого", 14.4.6. "Бүх зардал" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ЗДТГ-ын төсвийн захирагч Б.Бурмаа, сумын ИТХ-ын төсвийн захирагч Д.Дандар, соёлын төвийн эрхлэгч Г.Тунгалаг нарт хуулийн дагуу хариуцлага тооцох албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлж байна.

Илрүүлэлт:

1.Богд сумын ЗДТГ, ИТХ-ын 10-12 сарын нярвын тайлан болон цалингийн дэлгэрэнгүй цэст, нийгмийн даатгалын мэдээ, шатахууны тооцоог аудитад ирүүлээгүй.

2. Хоршоо хөгжүүлэх сангаас 2022 онд 9 хүнд 119,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байгаа бөгөөд оны эцэст 184,313.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гэж санхүүгийн тайланд тусгагдсан ба аудитаар тус сумын ЗДТГ-ын Хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтнээс сум хөгжүүлэх сангийн судалгааг удаа дараа холбогдон авсан боловч тайлант хугацаанд төлөгдсөн зээл, зээлийн хүүгийн орлого, гарсан зардлын дүнтэй таарахгүй байна.

3. Богд сумын орон нутгийн төсөвт байгууллагууд хариуцсан нягтлан бодогч нь ажлаа хаяж явсан гэх боловч Улаанбаатар хотоос цалингийн болон зардлын гүйлгээ хийж байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1. "Шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3. дахь "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" 20.2.9 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст Богд сумын орон нутгийн төсөвт байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албаар хяналт шалгалт хийлгэх, тус сумын санхүүгийн албыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Хариуцлага тооцуулах албан шаардлага							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Богд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй япон улсын тусламжаар өгсөн нэг бүр нь 6,000.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг мотор биетээр байхаар дутагдсан байна.	1	12,000.0					1	0		
Сумын төсөвт байгууллагууд санхүүгийн тайлан болон сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх, 8.9.2 дахь цаглаварт хугацаандаа Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй	3	0							3	0
Сумын ЗДТГ, ИТХ, соёлын төв, ОНХС, Сум хөгжүүлэх сан хариуцсан нягтлан бодогч Х.Пүрэвсүрэн ажлаа хаяж явснаас шалтгаалж тухайн байгууллагуудыг санхүүгийн тайланг хугацаандаа ирүүлээгүй, ба 2023.03.01-д санхүүгийн тайлангуудыг ирүүлсэн боловч орлого, зарлагын гүйлгээ дутуу санхүүгийн тайлан шаардлага хангахгүй байна	1	244,790.3			1	244,790.3				
Дүн	5	256,790.3			1	244,790.3	1	0	3	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 1,088.6 мянга, бууны албан татвар 290.0 мянга, малын тоо толгойн албан татвар 4,517.6 мянга, газрын төлбөр 2,045.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна	1	0					1	0
Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс 116 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг мэдээллийн хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.	1	0					1	0
Дүн	1	0					2	0

_____оОо_____